



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №25



2018 оны 7-р сарын 23-27-ны хооронд

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **1080** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 97(9%) галзуугийн эрсдэлд өртсөн, 974(90.1%) хачигт халдвар, 2(0.2%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 6(0.5%) боом, 1(0.1%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 974 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18.2%-иар, эпидемиологийн 29-р долоо хоногтой харьцуулахад 23.1%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



7 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар хачигт риккетсиозын 724 сэжигтэй тохиолдлын 141(19.5%), хачигт энцефалитын 164 сэжигтэй тохиолдлын 27(16.5%), хачигт боррелиозын 86 сэжигтэй тохиолдлын 22(25.6%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 113 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 97 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14.1%-иар, эпидемиологийн 29-р долоо долоо хоногтой харьцуулахад 66.6%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Ховд, Төв, Дорнод аймгийн 4 суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 6 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

1.4 Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Баянхонгор аймгийн Өлзийт суманд тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, тархвар судлал, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна.

1.5 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Увс аймгийн Улаангом сум, нийслэлийн ХУД-ээс бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй 2 тохиолдол бүртгэгдэж, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна.

1.6 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол:


Канад улсын иргэн. Өвчтөн “D” 34 настай, эмэгтэй. 2018 оны 3 дугаар сарын 16-29-ний хооронд Индонез улсад зорчих үедээ шумууланд хазуулсан өгүүлэмжтэй. 3 дугаар сарын 31-ний өдөр толгой өвдөх, дотор муухайрах, бүх бие янгинах, гүйлгэх шинж тэмдэг илэрч, Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний өдөр хэвтсэн. Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний 14 цагийн орчимд ЗӨСҮТ-ийн дуудлагын баг газар дээр нь очиж ажилласан. Өвчтнийг тусгаарлаж, хумхаа өвчний онош тодруулахаар сорьц дээжилж, ЗӨСҮТ-ийн лабораторид нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээгээр цусанд хумхаа өвчний үүсгэгчийн ДНХ тодорхойлогдоогүй онош үгүйсгэгдсэн.

1.7 Мэрэгч амьтны дуудлага:

7 дугаар сарын 24-нд СХД, БЗД-ийн хэмжээнд 2 удаагийн ирүүлсэн амьтны дуудлагад үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилгээ хийхээр хүлээн авав. Он гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 30 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Тарваган тахлын дархлаажуулалтын хамралт:

Дархлаажуулалтын хамралт улсын хэмжээнд 65.5 хувьтай байна. Хэнтий, Баян-Өлгий, Улаанбаатар, Төв аймгийн дархлаажуулалтын хамралт өндөр буюу 90-100%-тай Ховд 39.7%, Увс 46.5%-тай хамралттай байна.



ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны боом өвчин: Ховд аймаг

Ховд аймгийн Буянт сумын Цагаан эрэг багийн “Улаан-Үзүүр”, “Улаан-Худагтын ам” гэдэг газар 7-р сарын 24-ны өдөр малчин айлын 3 үхэрт мал, амьтны боом өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч 25-нд Аймгийн ХХААГазрын төв лабораторит шинжлүүлэхэд мал, амьтны боом өвчин болох нь тогтоогдсон. 7 дугаар сарын 25-нд тус суманд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон байна. Эрсдэлд өртсөн тохиолдол байхгүй.



Эх сурвалж: Ховд аймгийн ЗӨСТ

Мал, амьтны галзуу өвчин: Хөвсгөл аймаг

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Баянзүрх багийн “Цэцэрлэг”, “Бүгдгээн” гэдэг газар мал амьтны галзуу өвчин бүртгэгдсэн тухай мэдээлсэн. Тус суманд 14 хоногийн хязгаарлалтын дэглэм тогтоожээ. Эрсдэлд өртсөн тохиолдол байхгүй. Голомтот нутгийн 19 хүнд үзлэг хийж, 3 хүнд вакцин хийсэн. Нийт 8 өрхийн 38 хүн амд галзуу өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгаа хийгдсэн байна.

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн ЗӨСТ

Олон улсад:

Хэл хөхрөх өвчин: Кени улс

Кени улсын Накуру хотын Жилгил мужийн аж ахуйд хэл хөхрөх өвчин бүртгэгдэж, 100 хонь өртөмхий байснаас, 10 хонь өвчилж, 5 хонийг устгасан байна. Тус газарт хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалтын хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

ОХУ-ын Калининград мужид Африкийн гахайн мялзан өвчний улмаас 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

Саудын Араб улсын Ридах хотын Ар Рияд мужид шувууны томуугийн H5N8 вирусийн халдварын дэгдэлт шувууны аж ахуйд бүртгэгдэж, 14675 шувууг устгаж, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Мал, амьтны боом өвчин:

Тува мужийн Барун-Хемчикском мужид Bacillus anthracis хэвшлийн вирусээр үүсгэгдсэн мал, амьтны боом өвчин бүртгэгдэж, 33 үхэр өртсөнөөс, 1 үхэр өвчилж, 1 үхрийг устгасан байна. Мөн 32 үхэрт боомын вакцинжуулалт хийж, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: Promed

Рифт хөндийн чичрэг өвчин:

Уганда улсад 7-р сарын 17-28-ны хооронд Касейс, Исинширо, Ибанда, Мбарра, Сембембуле дүүрэгт Рифт хөндийн чичрэг өвчний 8 тохиолдол (6 батлагдсан, 2 сэжигтэй) үүнээс нас баралт 3 (нас баралтын түвшин 42%) мэдээлэгдсэн байна.

Эх сурвалж: Promed

Шүлхий өвчин:

БНХАУ-ын Гуандунг мужийн мал захад “О” хэвшлийн вирүсээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдэж, 32 гахай өртсөнөөс, 1244 гахайг устгаж, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Жич: Энэ долоо хоногт Архангай, Багануур, Баян-Өлгий, Өмноговь, Төв, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Завхан, Дундговь, Говь-Алтай аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?